Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны
...12... дугаар сарын ...27...-ны өдрийн А/401
дугаар тушаалын хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:**

- [√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- [ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

**Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:**

**Дагаж мөрдөх огноо:**

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:** 2023.12.27 А/401

| **Байгууллагын нэр:** | **Нэгжийн нэр:** |
|---|---|
| Мөрдөн байцаах алба | Тусгай субьектын үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасаг |
| **Албан тушаалын нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл:** |
| Эрүүгийн ахлах мөрдөгч | ТТ-4 |
| **Ажлын цаг:** | **Ажлын байрны албан ёсны байршил:** |
| 8 цаг | Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Самбуугийн гудамж-18 |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах. |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

**Албан тушаалын зорилго:**

-Харьяаллын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд Монгол улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын зааварт заасан үндэслэл журмын дагуу мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулж, цагдаагийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах.

-Цагдаагийн алба хаагчийн үйлдсэн нууц далд, зохион байгуулалттай үйлдэж байгаа гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил эрхэлж, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах.

| |
|---|
| 1.Харьяалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, чиг үүргийн бусад албадтай хамтран ажлын хэсэг удирдан, мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллах.<br>2.Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, мөрдөн шалгах ажиллагаа явуулах талаар чиглэлийн хэлтэс, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, цагдаагийн бусад албадтай хамтран ажиллах.<br>3.Хариуцсан чиглэлээр нууц далд, зохион байгуулалттай үйлдэгдэж байгаа нуугдмал гэмт хэрэг, сэжигтэй этгээдийн талаар мэдээлэл, баримт сэлт, нотлох баримтын эх сурвалж олох, цуглуулах, баримтжуулан илрүүлэх ажлыг бие даан хэрэгжүүлж, удирдан зохион байгуулах.<br>4.Удирдлагаас өгсөн үүргийн дагуу даалгасан ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх.<br>5.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийн хэрэгжүүлэх. |

| **Зорилт** | **Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг** | **Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт** | **Хариуцлага, оролцооны хэлбэр**<br>Туслах **–Т,**<br>Харилцан, гүйцэтгэх-**Г**<br>Хянах-**Х**<br>Шийдвэрлэх-**Ш** |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.1.Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын заавар, үйл ажиллагааны холбогдох журамд заасныг хэрэгжүүлэх;<br>1.2.Гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрэн сурвалжлах, олж тогтоох;<br>1.3.Гүйцэтгэх ажлын хэрэг, материал, маш нууц баримт бичиг, биет зүйлсийг биечлэн хариуцаж зөрчил дутагдал гаргасан тохиолдолд шууд удирдах даргад өөрийн биеэр танилцуулах:<br>1.4.Дээрх чиг үүргийг удирдлагын хяналт дор хэрэгжүүлж, зохион байгуулах. | Мөрдөн шалгах ажлын үр дүн дээшилж, гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтэд тодорхой үр дүн гарсан байна. | Г, Х<br>Г<br>Г<br>Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 2.1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.2.13, 6.2.14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх;<br>2.2.Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах чиглэлийн алба болон Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газруудтай хамтран ажиллах<br>2.3.Дээрх чиг үүргийг удирдлагын хяналт дор хэрэгжүүлж, зохион байгуулах. | Хамтын ажиллагаанд ахиц, үр дүн гарсан байна | Х, Ш<br>Х, Г<br>Х |

| | | | |
|---|---|---|---|
| 3 дугаар зорилтын хүрээнд | 3.1.Хариуцсан чиглэлийн нууц далд гэмт хэргийг бие даан илрүүлэх.<br>3.2.Харьяалуулсан чиглэлийн мэдээллийг гүйцэтгэх ажлын шугамаар олж шалгах, шийдвэрлэх:<br>3.3.Харьяалуулсан гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн бодлогын хүрээнд гүйцэтгэх ажлын заавbooрын дагуу мөрдөн тагнах хэрэг, сэжигтэй этгээдийг хянах ажиллагааг нээн баримтжуулалт явуулах:<br>3.4.Нууц далд аргаар гэмт хэрэг үйлдэгдсэн, үйлдэж болзошгүй объект, сэжигтэй этгээдүүдийн талаар иж бүрэн судалгаатай байж баяжилт хийж нөхцөл байдлыг тодорхойлох.<br>3.5.Гүйцэтгэх ажлын сонирхол татсан объект, чиглэлийн нөхцөл байдлыг судалж, дүн шинжилгээ хийж удирдлагад танилцуулах,<br>3.6.Хариуцсан чиглэлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тухай жилд хэрэгжүүлэх ажлын бодлого, төлөвлөгөөг боловсруулж биелэлтийг хангах:<br>3.7.Мэдээлэл шалгах, баримтжуулах ажлын хүрээнд Гүйцэтгэх ажлын тухай хууль, журам, зааварт заасан арга хувилбар, мөрдөн шалгах нууц ажиллагааны төлөвлөгөө, удирдлагын баталсан төлөвлөгөө тогтоолоор зохион байгуулах,<br>3.8.Харьяалуулсан чиглэлийн гэмт хэргийг илрүүлэхэд шаардлагатай байршилд, хүрэлцэхүйц мэдээллийн эх сурвалжийг зохион байгуулах | Харьяалуулсан чиглэлийн нөхцөл байдлын судалж, гэмт хэргийн талаар мэдээлэл олж баримтжуулан буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх | Г, Ш<br>Г,Ш<br>Г<br>Г<br>Г<br>Г<br>Г<br>Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 4.1.Удирдлагаас өгсөн үүргийг цаг тухайд нь биелүүлж, үр дүн биелэлтийг танилцуулах;<br>4.2.Удирдлагаас өгсөн үүргийг цаг тухайд нь биелүүлж, үр дүн биелэлтийг тооцож ажиллах.<br>4.2.Ажлаа долоо хоногоор төлөвлөн, өдөр тутмын тэмдэглэл, ГА-ын бүртгэлийг хөтөлж, сар бүр хийсэн ажлын мэдээг бичмэлээр тайлагнаж, гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг гаргаж дүгнүүлнэ. | Ажлын гүйцэтгэл сайжирна. | Г<br>Г<br>Г |
| Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн | 5.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх;<br>5.2.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн | - | Г<br>Г |

| | | | |
|---|---|---|---|
| бусад чиг үүргийг хэрэгжүүлэх | алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх;<br>5.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах. | | Г |

| III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| **Боловсрол** | Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| **Мэргэжил** | -Эрх зүй /0421/<br>-Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/ | |
| **Мэргэшил** | Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх. | |
| **Туршлага** | Цагдаагийн байгууллагад 6-аас доошгүй жил, үүнээс нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын офицер албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх | |
| **Ур чадвар** | Удирдан зохион байгуулах | Хариуцсан ажиллаа төлөвлөх, зохион байгуулах Ажлын хэсгийн албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах |
| | Дүн шинжилгээ хийх | Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалгах, нягтлах, Нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр, гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах, дүгнэх, Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх. |
| | Асуудал шийдвэрлэх | -Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх;<br>-Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах;<br>-Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох |
| | Манлайлах | -Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дууриал үзүүлэх;<br>-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах;<br>-Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх. |
| | Бусад | -Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх.<br>-Компьютерийн Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх.<br>-Нууц хадгалах. |

| IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ | |
|---|---|
| **Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:**<br>Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дарга, Мөрдөн байцаах албаны Тусгай субьектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн дарга | |
| **Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:**<br>Батлагдсан орон тоо. | **Бусад харилцах субъект:**<br>**Шууд харилцах байгууллага:**<br>-Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;<br>**Шууд бус харилцах байгууллага:**<br>-Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, |

| | |
|---|---|
| | иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/. |

| **V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:** | |
|---|---|
| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:** |
| Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА<br>Т.ГАНЗОРИГ<br>2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр | Байгууллагын нэр: ............................<br>Шийдвэрийн огноо: ...........................<br>Дугаар:.............................................. |
| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** | |
| Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР<br>Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр<br>Дугаар: А/401<br><br>ДАРГА,<br>ЦАГДААГИЙН ХУРАНДАА Т.СҮХБОЛД<br>2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр | |

ТАНИЛЦСАН:

| |
|---|
| Албан тушаалтан: ........................................................................<br>........................................................................<br>........................................................................ |
| 20...оны .... дугаар сарын ....-ны өдөр |